

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 12 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 269

Улаанбаатар хот

Г Хорооны 2009 оны 174 дугаар тогтоолоор батлагдсан Г  
журмын зарим заалтыг өөрчлөн найруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 174 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх, аудитын байгууллагад эрх олгох, аудитороос шалгалт авах, аудитор томилох тухай” журмын нэр, 2.1.1, 2.1.3, 3.1.4, 4.1.3 дахь заалтуудыг дор дурьдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ Журмын нэр:**

“Даатгалын байгууллагад аудит хийх, аудитын байгууллагад эрх олгох, аудитороос шалгалт авах, аудитор томилох журам” гэснийг “Даатгалын байгууллагад аудит хийх, аудитын байгууллагад эрх олгох, томилох, аудитороос шалгалт авах журам” гэж,

**2/ 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:**

“Аудитын байгууллага нь Сангийн яамнаас тусгай зөвшөөрөл авснаас хойш 5 жил үйл ажиллагаагаа тасралтгүй явуулсан байх” гэснийг “Аудитын байгууллага нь Сангийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан байх” гэж,

**3/ 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:**

“Даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий 2-оос доошгүй үндсэн аудитортой байх” гэснийг “Даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий 2-оос доошгүй аудитортой байх, аудитын ажлын багт тэдгээр аудиторууд ажилласан байх” гэж,

**4/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:**

“Тухайн аудитын байгууллагын дүрэм, аудитын үйлчилгээний дотоод стандарт /даатгалын байгууллагад аудит хийх асуудлыг заавал тусгасан байна/, компанийн танилцуулга болон сүүлийн 3 жилд аудит хийсэн компаниудын жагсаалт” гэснийг “Тухайн аудитын байгууллагын дүрэм, даатгалын аудитын дотоод стандарт, компанийн танилцуулга болон сүүлийн 3 жилд аудит хийсэн компаниудын жагсаалт” гэж,

**5/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:**

“Аудитын байгууллагад үндсэн аудитороор 3 жил ажилласан болохыг батлах баримт бичиг /нийгмийн даатгалын дэвтэр, ажил орсон тухай тушаал, хөдөлмөрийн гэрээ/-ийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар” гэснийг “Тухайн аудитын байгууллагын үндсэн эсвэл гэрээт аудитор эсэхийг батлах баримт бичиг /нийгмийн даатгалын дэвтэр, ажил орсон тухай тушаал, хөдөлмөрийн гэрээ болон бусад/-ийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар” гэж.

2. Тогтоолд өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн тайлагнал, аудит, үнэлгээний чанарын хяналтын газар /М.Болортуяа/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## **ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ ХИЙХ, АУДИТЫН БАЙГУУЛЛАГАД ЭРХ ОЛГОХ, ТОМИЛОХ, АУДИТОРООС ШАЛГАЛТ АВАХ ЖУРАМ**

*/Журмын нэрэнд Хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 269 дугаар тогтоолоор  
өөрчлөлт орсон/*

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 33.2.2, болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2 дахь заалтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос даатгалын байгууллагад аудит хийх эрхийг аудитын байгууллагад олгох, эрхийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, аудиторос шалгалт авах, аудиторыг томилох, даатгалын байгууллагад аудит хийх горимыг тогтоох болон эрх бүхий аудитын байгууллага энэхүү журамд заасан шаардлагыг хэрхэн биелүүлэн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

### **Хоёр. Аудитын байгууллагад тавигдах шаардлага**

2.1. Дараах шаардлагыг хангасан эрх бүхий аудитын байгуулагад даатгалын байгууллагад аудит хийх эрхийг олгоно:

2.1.1. аудитын байгууллага нь Сангийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан байх;  
*/Энэ заалтад Хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 269 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/*

2.1.2. аудитын тухай хуулийн 25, 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх;

2.1.3. даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий 2-оос доошгүй аудитортой байх, аудитын ажлын багт тэдгээр аудиторууд ажилласан байх;

*/Энэ заалтад Хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 269 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/*

2.1.4. даатгалын байгууллагад аудит хийх аудиторууд Хорооноос зохион байгуулах эрх олгох сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх;

2.1.5. даатгалын байгууллагад аудит хийх аудиторууд нь Аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байх;

2.1.6. даатгалын байгууллагад аудит хийхэд аливаа ашиг сонирхлын зөрчилгүй байх.

### **Гурав. Даатгалын байгуулагад аудит хийх эрх авахад бүрдүүлэх баримт бичиг**

3.1. Даатгалын байгууллагад аудит хийх хүсэлтэй бөгөөд энэхүү журмын 2.1-д заасан шаардлагыг бүрэн хангаж буй аудитын байгууллага нь дор дурдсан баримт бичгийг тус Хороонд ирүүлнэ:

3.1.1. энэхүү журмын нэгдүгээр хавсралт ёсоор баталсан маягтын дагуу гаргасан эрх олгохыг хүссэн өргөдөл;

3.1.2. аудитын байгууллагын улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.3. энэхүү журмын хоёр, гуравдугаар хавсралтын дагуу гаргасан аудитын байгууллага, түүний удирдлага, аудиторуудын тодорхойлолт;

3.1.4. тухайн аудитын байгууллагын дүрэм, даатгалын аудитын дотоод стандарт, компанийн танилцуулга болон сүүлийн 3 жилд аудит хийсэн компаниудын жагсаалт;

*/Энэ заалтад Хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 269 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/*

3.1.5 Хорооноос зохион байгуулах эрх олгох сургалтанд оролцож, тэнцсэн аудиторуудын эрхийн үнэмлэхний хуулбар;

3.1.6 даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий аудиторууд нь ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй, эсхүл зөрчилгүйд тооцогдох хугацаа нь дууссан эсэх талаарх МНБИ-ээс гаргасан лавлагаа.

### **Дөрөв. Аудиторт даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох, сургалт зохион байгуулах, шалгалт авах**

4.1. Даатгалын байгууллагад аудит хийх эрх авахыг хүссэн аудитор дараах баримт бичгийг тус Хороонд ирүүлнэ:

4.1.1. эрх авахыг хүссэн өргөдөл;

4.1.2. мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээ, аудит ба баталгаажуулах үйлчилгээ эрхлэх эрхийн батламжийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

4.1.3. Тухайн аудитын байгууллагын үндсэн эсвэл гэрээт аудитор эсэхийг батлах баримт бичиг /нийгмийн даатгалын дэвтэр, ажил орсон тухай тушаал, хөдөлмөрийн гэрээ болон бусад/-ийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

*/Энэ заалтад Хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 269 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/*

4.1.4. иргэний үнэмлэхний хуулбар;

4.1.5. 3 хувь цээж зураг /3x4 хэмжээтэй/.

4.2. Даатгалын аудитын үйл ажиллагаа явуулах эрх олгох шалгалтын комисс /цаашид “Комисс” гэх/:

4.2.1. аудиторт даатгалын аудитын үйл ажиллагаа явуулах эрх олгоход шаардлагатай сургалт, шалгалтыг орон тооны бус комисс гүйцэтгэнэ;

4.2.2. комисс нь комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 5-аас доошгүй хүний бүрэлдхүүнтэй байх бөгөөд тэдгээрийг тус Хорооны Ажлын албанаас оруулсан саналыг үндэслэн Хорооны даргын тушаалаар томилно;

4.2.3. комиссын дарга нь Хорооны гишүүн байх ба нарийн бичгийн даргын үүргийг Хорооны аудитын чанарын хяналт хариуцсан нэгжийн ажилтан гүйцэтгэнэ;

4.3. Комиссын гишүүд дараах эрх, үүрэгтэй байна:

4.3.1. шалгалтын асуулт, тестийг бусдаар бөглүүлэх, хуулах зэрэг үйлдэл хийсэн оролцогчдыг протоколд тэмдэглэж, шалгалтаас хасах;

4.3.2. шалгалтын тест болон асуултын нууцыг чанд хадгалах;

4.3.3. шалгалтын комиссын үйл ажиллагаанд өөрийн биеэр оролцох;

4.3.4. шалгалтын дүнг Хороонд танилцуулах.

4.4. Комисс нь энэ журамд заасан шийдвэрийг гишүүдийн олонхийн саналаар гаргана.

4.5. Комиссын нарийн бичгийн дарга дараах эрх, үүрэгтэй:

4.5.1. шалгалтад хамрагдахаар өргөдөл гаргасан этгээдийн баримт бичгийг энэхүү журамд нийцүүлэн хүлээн авч бүртгэх;

4.5.2. шалгалтад орохоор өргөдөл гаргасан этгээдэд Хорооны цахим хуудас болон мэдээллийн бусад арга хэрэгслээр сургалт болон шалгалтын товын зарлах;

4.5.3. сургалтын бэлтгэл ажлын удирдлагаар хангах, шалгалтыг зохион байгуулах;

4.5.4. шалгалт болон комиссын хуралдааны тэмдэглэл хөтөлж, баримт бичгийг цэгцлэн Хорооны архивт шилжүүлэх.

#### 4.6. Сургалт зохион байгуулах

4.6.1. сургалтын хөтөлбөр, агуулга зэргийг комиссын нарийн бичгийн дарга хариуцах ба сургалт явуулах тухайн жил бүр хөтөлбөрийг Хорооны даргаар батлуулна;

4.6.2. сургалтыг олон нийтэд зар түгээнээс хойш ажлын 10-с доошгүй хоногийн дараа зохион байгуулна;

4.6.3. сургалтыг техник, тоног төхөөрөмжийн шаардлага хангасан орчинд, гарын авлага, тараах материал нь сургалтад оролцогч бүрт хүртээмжтэй байхаар зохион байгуулна;

4.6.4. сургалт болон шалгалтын төлбөрийн хэмжээг Хороо тогтооно.

#### 4.7. Даатгалын байгууллагад аудитын хийх эрх олгох шалгалтыг зохион байгуулах

4.7.1. шалгалт нь хоёр шатлалтай байх бөгөөд эхний шатанд тестээр, хоёрдугаар шатанд ярилцлагад оруулах замаар шалгалтыг авна;

4.7.2. шалгалтад тус Хорооноос зохион байгуулсан сургалтын 80-аас дээш хувьд хамрагдсан аудиторыг оруулна;

4.7.3. тестийн хувилбар боловсруулах, нэгтгэх ажлыг комиссын шийдвэрээр томилогдсон тодорхой гишүүн гүйцэтгэх ба тестийн эцсийн хувилбарыг комиссын хурлаар батлан битүүмжлэнэ;

4.7.4. тестийг битүүмжилсэн байдлаар шалгалт авах танхимд хүргэх ба шалгалтад оролцогчдыг байлцуулан битүүмжийг задална;

4.7.5. тестийн асуултын 60 буюу түүнээс дээш хувийг үнэн зөв хариулсан аудиторыг дараагийн хоёрдугаар шатны шалгалтад оруулна;

4.7.6. тестийн хариуг эхний шатны шалгалтын дараа задлах бөгөөд комисс боломжтой гэж үзсэн тохиолдолд нэгдсэн журмаар шалгалт өгсөн этгээдүүдийн хүсэлтийг үндэслэн тэдгээрийг гүйцэтгэсэн тестийн хариуных нь эх материалтай танилцуулж болно;

4.7.7. шалгалтын хоёрдугаар шатанд ярилцлага хэлбэрээр асуулт хариулт авах ба асуултын агуулга, хүрээ болон асуултын жагсаалтыг Комисс батална.

4.7.8. асуулт хариултад шалгуулагч тус бүрээс 3-аас доошгүй асуулт асуух ба хариултын үндэслэл, мэдлэг, чадварын байдлаас хамаарч хариултыг дүгнэнэ. Асуултын 50-иас дээш хувьд хангалттай гэх дүгнэлт авсан аудиторыг 2 дахь шатанд тэнцүүлнэ.

4.7.9. хоёр дахь шатанд тэнцсэн аудиторт комиссын шийдвэрийг үндэслэн Хороо 3 жилийн хугацаатайгаар эрх олгоно;

4.7.10. аудитын үйл ажиллагаа явуулах эрхийн үнэмлэхийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үйлдэнэ.

#### 4.8. Даатгалын байгууллагад аудитын хийх эрх бүхий аудиторыг аттестатчилах

4.8.1. аудитор даатгалын байгууллагад аудит хийх эрхийн хугацаа нь дуусахаас 3 сарын өмнө Хороонд хандаж аттестатчилалд хамрагдах өргөдлийг энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргана;

4.8.2. даатгалын аудитын үйл ажиллагаа явуулах эрх авсан хүмүүсийг давтан сургалтанд хамруулж аттестатчилах ажлыг энэхүү журмын 4.2-т заасан орон тооны бус комисс зохион байгуулна;

4.8.3. комисс нь жилд 2-оос доошгүй удаа давтан сургалт, аттестатчилах шалгалтыг зохион байгуулах ба уг арга хэмжээнд даатгалын байгууллагад аудит хийх эрхийн хугацаа нь дуусгавар болж буй өргөдөл гаргасан аудиторуудыг хамруулна;

4.8.4. давтан сургалт, аттестачлах шалгалтыг энэхүү журмын 4.6, 4.7-д заасан журмын дагуу зохион байгуулах ба аттестатчилах шалгалтад тэнцээгүй аудиторын эрхийг комиссын шийдвэрийг үндэслэн Хорооны шийдвэрээр хүчингүй болгоно;

4.8.5. аттестатчилах шалгалтад тэнцээгүй буюу оролцоогүй аудитор нь даатгалын аудитын үйл ажиллагаа явуулах эрх олгох дараагийн ээлжит шалгалтад дахин хамрагдах эрх нь нээлттэй байна.

4.9. Дор дурдсан тохиолдолд Хороо тухайн аудиторын эрхийн хугацаа дуусгавар болж буй эсэхээс үл хамааран хугацаанаас өмнө аттестатчилалд хамрагдахыг шаардаж болно:

4.9.1. тухайн аудиторын харьяа аудитын байгууллага нь түүнийг дахин шалгалтанд оруулах үндэслэл бүхий хүсэлт гаргасныг Хороо хүлээн зөвшөөрсөн;

4.9.2. тухайн аудиторын үйлчлүүлэгчдээс үндэслэл бүхий гомдол гаргасан;

4.9.3. Хорооноос томилогдсон шалгалтын ажлын хэсгээс тухайн аудиторын мэргэжлийн мэдлэг чадвар нь шаардлага хангахгүй байгаа, ажилдаа хариуцлага алдсан тухай дүгнэлт гаргасан.

4.10. Аудиторын эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

4.10.1. Хороо шаардлагатай гэж үзвэл энэ журмын 5.4-т заасан үндэслэлээр аудиторын эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгож болно.

#### **Тав. Аудитын байгууллагад эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

5.1. Хороо аудитын байгууллагаас ирүүлсэн бүрдэл хангасан хүсэлт болон бусад шаардлага хангасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 45 хоногийн дотор хянан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, эрх олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

5.2. Хороо даатгалын байгууллагад аудит хийх эрхийг 3 жилийн хугацаатайгаар олгоно.

5.3. Даатгалын байгууллагад аудит хийх эрхийг сунгах хүсэлтийг тус Хорооны Ажлын албанд гаргах ба ажлын алба нь тухайн байгууллагын гүйцэтгэлийн үр дүн, чанарыг үндэслэн эрх сунгах эсэх асуудлаар холбогдох саналыг боловсруулж Хорооны хурлаар шийдвэрлүүлнэ.

5.4. Хороо нь дараах үндэслэлээр даатгалын байгууллагад аудит хийх эрхийг түдгэлзүүлж болно:

5.4.1. санхүүгийн тайланг санаатай буюу санамсаргүйгээр буруу баталгаажуулсан, аудитын үйл ажиллагааны зарчмыг зөрчиж, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахууц нөхцөл байдал үүсгэсэн;

5.4.2. Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй;

5.4.3. энэхүү журамд заасан шаардлагыг зөрчсөн буюу шаардлага хангахгүй болсон;

5.4.4. Хорооноос ногдуулсан торгууль, төлбөрийг тогтоосон хугацаанд төлж барагдуулаагүй;

5.4.5. эрх олгосноос хойш 1 жилийн дотор аудитын үйл ажиллагаагаа явуулаагүй;

5.4.6. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл;

5.4.7. энэ журмын 7.3-ийг зөрчсөн;

5.4.8. даатгалын зах зээлийн нэр хүнд, тогтвортой байдалд хохирол учирхуйц ёс зүйн болон үйл ажиллагааны ноцтой алдаа гаргасан, ашиг сонирхолын зөрчил бүхий нөхцөл байдал үүссэн гэж үзсэн.

5.5. Хороо нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх хүртэл даатгалын байгууллагад аудит хийх эрхийг 6 хүртэл сарын хугацаагаар түдгэлзүүлж болно.

5.6. Хороо нь дараах үндэслэлээр даатгалын байгууллагад аудит хийх аудитын байгууллагын эрхийг цуцлах болон хүчингүй болгоно:

5.6.1. аудитын байгууллага эрхээ цуцлуулахаар хүсэлт гаргасан;

5.6.2. Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг ноцтойгоор биелүүлээгүй, энэхүү журмын 5.5-д заасан эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд зохих үүргийн биелэлтийг хангаагүй;

5.6.3. аудитын байгууллага нь даатгалын байгууллагад аудит хийх эрхийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

5.6.4. холбогдох хууль, журам болон энэ журамд заасан шаардлага, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа болон ноцтой зөрчсөн;

5.6.5. даатгалын байгууллагад аудит хийх аудитын байгууллага эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

5.6.6. даатгалын байгууллагын нууцлалтай холбогдсон мэдээллийг бусдад задруулсан буюу дамжуулсан болох нь нотлогдсон;

5.6.7. алдаатай болон хуурамч дүгнэлт гаргасан;

5.6.8. даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий аудиторын тоо 2-оос доош болсон.

5.7. Хороо эрх олгох, эрхийг сунгахаас татгалзсан тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргасан аудиторт албан ёсоор хүргүүлнэ.

5.8. Хорооны Тамгын газрын тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан нь аудиторуудад эрх олгосон, түдгэлзүүлсэн, цуцалсан, аттестатчилсан талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөнө.

5.9. Даатгалын байгууллагад аудит хийх эрх авсан аудитын байгууллагын ажиллах эрхийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай шийдвэрийг ажлын 10 хоногт багтаан тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан Хорооны цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэд мэдээлнэ.

### **Зургаа. Аудиторыг томилох**

6.1. Даатгалын байгууллага нь санхүүгийн тайлангаа баталгаажуулах зорилгоор даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий аудитын байгууллагыг томилно.

6.2. Даатгалын байгууллага аудитын байгууллагыг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор хороонд бичгээр мэдэгдэнэ.

6.3. Даатгалын байгууллага даатгалын байгууллагад аудит хийх эрхгүй этгээдээр аудит хийлгэсэн тохиолдолд Хороо даатгалын байгууллагын оролцоогүйгээр эрх бүхий аудитын байгууллага томилон санхүүгийн тайланд дахин аудит хийлгэнэ.

6.4. Энэхүү журмын 6.3-т заасан аудиторыг Хороо томилохдоо тухайн тайлангийн жилд хамгийн олон даатгалын компанид аудит хийсэн аудитын байгууллагыг эхний ээлжид сонгох зарчмыг баримтлана. Тухайн сонгосон байгууллага уг ажлыг гүйцэтгэх боломжгүй тухайгаа мэдэгдсэн тохиолдолд Хороо дараагийн эрх бүхий аудитын байгууллагад санал тавина.

6.5. Тус Хорооноос эрх аваагүй аудитын байгууллагаас даатгалын байгууллагын үйл ажиллагааны талаар гаргасан аливаа тайлан, дүгнэлт хүчин төгөлдөр бус байна.

6.6. Энэ журмын 6.3-т заасны дагуу Хорооноос томилсон аудитын байгууллагын үйчилгээний зардлыг зөрчил гаргасан даатгалын байгууллага хариуцна.

### **Долоо. Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагаа**

7.1. Даатгалын тухай хуулийн 33.2.2 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2 дахь заалтын дагуу тус Хорооноос эрх авсан аудитын байгууллага нь даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компани, даатгалын зуучлагч болон даатгалын хохирол үнэлэгчийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж болно. Ингэхдээ Компанийн тухай хуулийн 86.1-д заасан этгээдүүдтэй гэрээ байгуулахыг хориглоно.

7.2. Даатгалын байгууллагад аудит хийх эрх авсан аудитын байгууллага нь даатгалын байгууллагатай Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн гэрээ байгуулах ба аудитор нь Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан шаардлагыг ханган холбогдох ажлыг нэмж гүйцэтгэнэ:

7.2.1. даатгалын байгууллагын санхүүгийн тайлан (даатгалтай холбоотой санхүүгийн нэмэлт тайлан мэдээ, мэдээлэл, орлого, зарлагын тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, хуримтлагдсан ашгийн тайлан, санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга), данс бүртгэл, бусад шаардлагатай санхүүгийн баримт, материалыг шалган баталгаажуулах;

7.2.2. аудитын үйл ажиллагаанд аудитын олон улсын болон үндэсний стандарт, мөн даатгалын салбарын олон улсын санхүүгийн тайлагналын стандартыг мөрдөх;

7.2.3. санхүүгийн баримтад тулгуурлан магадлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;

7.2.4. даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, заавар, журмын дагуу нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн хөтлөх, олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд нь даатгагчид туслах, зөвлөгөө өгөх;

7.2.5. давхар даатгалын үйл ажиллагаа нь Хорооноос баталсан “Давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ын дагуу явж буй эсэх болон даатгагчийн давхар даатгалын бодлого, гэрээ, тайлан, давхар даатгалын нөхөн олговрын төлөгдсөн байдал, хураамж, давхар даатгагч компанийн санхүүгийн болон төлбөрийн байдлын талаар үнэлэлт, дүгнэлт гаргах;

7.2.6. мөнгө угаах, алан хядах ажиллагааны эсрэг хууль тогтоомжийг биелүүлж буй эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

7.2.7. даатгалын нөхөн олговор олголтын болон баримт бүрдүүлэлтийн байдалд үнэлгээ өгөх;

7.2.8. даатгалын гэрээт баталгааны тооцоог нарийвчлан үзэх;

7.2.9. даатгагчийн төлбөрийн чадвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхид үнэлэлт дүгнэлт өгөх;

7.2.10. даатгагчийн эд хөрөнгийн чанар, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр, компанийн хувьцаа, ногдол ашиг хуваарилалт, зээл олголтын байдлыг хянаж, үнэлэлт дүгнэлт гаргах;

7.2.11. даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, хуваарилалт нь зохих журмын дагуу байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;

7.2.12. даатгалын нөөц сангуудийн байршлыг шалгаж баталгаажуулах;

7.2.13. даатгагчийн гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагын хэмжээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хоорондын харьцааг хянаж, дүгнэлт гаргах.

7.3. Аудитор нь шалгаж судалсан санхүүгийн тайлан, баримтад хувийн тэмдгээ дар ах бөгөөд аудитын байгууллагын дарга нь аудиторын гаргасан дүгнэлт, зөвлөмжид санхүүгийн тайланд хийсэн тохируулгын болон залруулгын бичилтийг хавсарган баримт бүрд гарын үсэг зурж, байгууллагын тамга тэмдгээ дарж баталгаажуулсны дараа холбогдох материалыг багцаар нь Хороонд хүргүүлнэ.

7.4. Аудитын байгууллага нь даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан дараах дүгнэлтийн талаар Хороонд нэн даруй мэдэгдэнэ:

7.4.1. даатгалын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу тухайн даатгалын байгууллагыг төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй;

7.4.2. даатгалын үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдсэн байж болзошгүй;

7.4.3. даатгагч Даатгалын тухай хуулийн 22, 23, 24, 25, 26, 27 дугаар зүйлийг ямар нэг хэлбэрээр зөрчсөн гэж үзсэн;

7.4.4. тухайн байгууллага санхүүгийн хүндрэлд орж болзошгүй болсон;

7.4.5. даатгуулагчдын эрх ашгийг зөрчсөн;

7.4.6. шударга бусаар ажилласан;

7.4.7. хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн үйл ажиллагаанд оролцсон.

### **Найм. Хяналт, хариуцлага, маргаан шийдвэрлэх**

8.1 Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавьж, шалгалт хийх ба холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2 Хороо өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар эрх эзэмшигчдийн хооронд болон эрх эзэмшигч, үйлчлүүлэгчдийн хооронд гарсан маргааныг шийдвэрлэнэ.

8.3 Аудитор, үйлчлүүлэгч нар нь Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл тус Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

8.4 Хяналтын зөвлөлийн гаргасан шийдвэрийг гомдол гаргагч эс зөвшөөрвөл шүүхэд хандаж болно.



ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ ХИЙХ  
АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,  
Засгийн газрын IV байр  
Бага тойруу-6,  
Улаанбаатар-46,  
Монгол Улс.

Хэнээс:

(*өргөдөл гаргагч хуулийн этгээдийн хаяг, байршил, утас, факс, электрон шуудангийн хаягийг бүрэн дэс дарааллаар нь бичнэ үү.*)

.....  
*/хуулийн этгээдийн нэр/*

.....  
*/ХК, ХХК/*

Аудитын байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон нэмэлт үйл ажиллагааны талаар бичих:

- 1/ .....
- 2/ .....
- 3/ .....
- 4/ .....
- 5/ .....

*/байгууллагын үйл ажиллагааны төрөл/*

Аудитын байгууллагын үүсгэн байгуулагч иргэд, хуулийн этгээд нь дараах мэдээллийг үнэн зөв бичнэ үү. Үүнд:

№	Овог, нэр <i>/Хуулийн этгээдийн нэр/</i>	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар <i>/Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/</i>	Хаяг	Хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ <i>(мянган төгрөгөөр)</i>

Аудитын байгууллагын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/ нь өөрийн хууль ёсны өмчлөлд байгаа мөнгөн хөрөнгөөр хувь нийлүүлсэн болно.

Аудитын байгууллагын захирал, аудиторууд нь Аудитын тухай хуулийн 17, 25.2-т тус тус заасан шаардлагыг хангасан дараах хүмүүс ажиллаж байгаа болно. Үүнд:

№	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн	Аудитын байгууллагад
---	-----------	-----------------------------	-------------------	--------------------	----------------------

				дугаар	эрхлэх албан тушаал

Даатгалын байгууллагад аудит хийх эрх хүссэн Хороонд бүрдүүлж хүргүүлсэн баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Аудитын тухай хууль, Даатгалын тухай хуульд нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны ..... дугаар сарын .....-ны өдрийн ..... дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх, аудитын байгууллагад эрх олгох, томилох, аудитороос шалгалт авах журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт ямарваа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, баримт бичгүүдийг хүлээн авч, хянан шийдвэрлэж Даатгалын байгууллагад аудит хийх эрх олгоно уу.

Даатгалын байгууллагад аудит хийх эрх авсан тохиолдолд Аудитын тухай хууль, Даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

**ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:**

*/тамга, тэмдэг/*

*/...../*

*/хуулийн этгээдийн нэр/*

*/...../*

*/албан тушаал/*

*/...../*

*/гарын үсэг/*

*/...../*

*/овог, нэр/*

## АУДИТЫН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ

А. Аудитын байгууллагад ямар албан тушаал эрхэлдэг талаар тэмдэглэнэ:

- Байгууллагын дарга
- Орлогч дарга
- Бусад .....   
*/Албан тушаалыг тодорхой бичих/*

Б. Аудитын байгууллага, түүний удирдлага нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ үү. Үүнд:

### 1. Аудитын байгууллага:


- Оноосон нэр:
- Байгуулагдсан он, сар, өдөр:
- Үйл ажиллагаа эрхлэх хугацаа:
- Байршил буюу хаяг:
- Улсын бүртгэлийн дугаар:
- Регистрийн дугаар:
- Аудитын байгууллагын удирдлагын овог, нэр:
- Аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон таницлуулга:

.....  
.....  
.....  
.....  
.....

*/эрхэлж ирсэн үйл ажиллагаа тус бүрийг эрхэлбэн хугацаагаар нь, хараат буюу охин компанитай эсхүл нэгжтэй эсэх, тэдгээрийн болон тухайн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн, байршил, өмчлөлийн байдал, бусад байгууллагад хувь нийлүүлсэн хөрөнгө зэргийг хамруулан бичнэ/.*

## 2. Удирдлага:

- Овог, нэр:
- Эрхлэж буй албан тушаал:
- Иргэний харъяалал:
- Иргэний үнэмлэхний дугаар:
  - Регистрийн дугаар:
  - Нийгмийн гарал:
- Гэр бүлийн байдал:
- Гэрийн хаяг:
- Утасны дугаар:



- Боловсролын талаар /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

- Ажлын туршлагын талаар:

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

“ .....- Аудит” ХХК нь Аудитын байгууллагын хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулах бөгөөд холбогдох материалуудыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

/...../  
/хуулийн этгээдийн нэр/

/...../  
/албан тушаал/

/...../  
/гарын үсэг/

/...../  
/овог, нэр/

## АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АУДИТОРЫН ТОДОРХОЙЛОЛТ


А. Аудитын байгууллагад ямар албан тушаал эрхэлдэг талаар тэмдэглэнэ:

- Үндсэн аудитор
- Бусад .....   
*/Тодорхой бичих/*

Б. Аудитын байгууллагын аудитор нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ үү. Үүнд:

### 1. Аудитор:

- Овог, нэр:
- Иргэний харьяалал:
- Иргэний үнэмлэхний дугаар:
- Регистрийн дугаар:
- Нийгмийн гарал:
- Гэр бүлийн байдал:
- Гэрийн хаяг:
- Утасны дугаар:
- Төрөл төрөгсөд болон ам бүлийн тоо:



Товч намтар түүх:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

*(Урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, даатгалын байгууллагатай харьцаж байсан түүх, даатгалын байгууллагын хувь нийлүүлэгч эсэх, Аудитын болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчиж хариуцлага хүлээж байсан эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдсэн эсэх зэрэг тухайн үйл ажиллагааг эрхэлхэд аливаа сонирхлын зөрчил бүхий нөрцөл байдал байгаа эсэхийг тодорхой гаргацтай, үнэн зөв бичнэ):*

• Боловсролын талаар (Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ):

№	Хаана ямар сургууль	Элссэн он сар	Төгссөн он сар	Эзэмшсэн мэргэжил	Диплом № Гэрчилгээ №

• Ажил, мэргэшлийн туршлагын талаар:

№	Хаана ажиллаж байсан (албан газар тухайн үеийн нэрээр бичнэ)	Албан тушаалд ажилласан	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

**В.** Даатгалын байгууллагад аудит хийх эрх анх удаа авч байгаа эсхүл аттестатчилах шалгалтад орж буй эсэх

1/ анх удаа

2/ дахин

Хэрэв /Гийм/ буюу дахин гэснийг бөглөсөн бол ямар шалтгаанаар эрх хүссэн тухай тодорхой бичиж, өмнө нь аль нэгэн даатгалын байгууллагад аудит хийсэн эсэх талаар дэлгэрэнгүй тайлбар бичнэ үү.

.....  
 .....  
 .....

**ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ**

/...../  
 (гарын үсэг)

/...../  
 (овог, нэр)

Он, сар, өдөр


“Даатгалын байгууллагад аудит хийх, аудитын байгууллагад эрх олгох, томилох, аудиторос шалгалт авах журам” -ын 4 дүгээр хавсралт



МОНГОЛ УЛС

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Дугаар.....



/Тэмдэг/

-----ХХК-ийн аудитор

-----овогтой

-----д

Санхүүгийн зохицуулах хорооны 20...оны  
... -р тогтоолоор даатгалын компанийн  
санхүүгийн тайланд аудит хийх эрхийг  
20--- оны --- сарын --- өдрийг хүртэл олгов.

Санхүүгийн зохицуулах хорооны  
Дарга Д.Баярсайхан

20... оны ... сарын ... өдрийг хүртэл сунгав.

Санхүүгийн зохицуулах хорооны  
Дарга Д.Баярсайхан

20... оны ... сарын ... өдрийг хүртэл сунгав

Санхүүгийн зохицуулах хорооны  
Дарга Д.Баярсайхан

“Даатгалын байгууллагад аудит хийх, аудитын байгууллагад эрх олгох,  
томилох, аудитороос шалгалт авах журам” -ын 5 дугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ ХИЙХ  
ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . . оны . . . сарын . . . өдөр  
хот

Улаанбаатар

Монгол Улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Даатгалын тухай хууль”, “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль” болон бусад хууль тогтоомж, Хорооны 2009 оны ... дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх, аудитын байгууллагад эрх олгох, томилох, аудитороос шалгалт авах журам”-д заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ өдрийн \_\_\_\_\_ дугаар тогтоолыг үндэслэн \_\_\_\_\_ хот, аймаг дахь \_\_\_\_\_ тоот регистрийн дугаар бүхий \_\_\_\_\_ тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй

-Д

(ХХК, ХК)

зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

"Тэмдэг"





**МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

\_\_\_\_\_ **ТООТ**

**ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ**

“Тэмдэг”

Даатгалын байгууллагад аудит хийх аудитын байгууллагад зориулсан тэмдэглэлүүд

(Энэхүү хавсралт нь эрхийн гэрчилгээний хамт хүчинтэй)

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: \_\_\_\_\_

ХОЁР. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хаяг	Утас, факс, и-мэйл хаяг	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

ГУРАВ. Эрхийн тэмдэглэл:

Д/д	Үйл ажиллагааны төрөл	Эрх олгосон огноо	Эрх олгосон шийдвэрийн дугаар	Эрхийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар

ДӨРӨВ. Нэмэлт өөрчлөлт

№	Өөрчлөлтийн тэмдэглэл	Өөрчлөлтийг бүртгэсэн огноо, тэмдэг, гарын үсэг